

**“MNS 6580 Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний төлөвлөлт, ерөнхий шаардлага” стандартын төслийн саналын нэгдсэн товчоо**

2019 оны 07 дугаар сарын 19 өдөр

Улаанбаатар хот

“MNS 6580:.... Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний төлөвлөлт, ерөнхий шаардлага” стандартын төсөлд дараах саналууд ирсэн бөгөөд стандарт боловсруулах ажлын хэсгээс зарим саналуудыг тусгаж, тусгах боломжгүй саналууд дээр тайлбар хийлээ.

1. Радио телевизийн сүлжээ
2. Монголын цахилгаан холбоо ХК

№	Төслийн эхний хувилбар	Саналын товч агуулга	Төсөлд тусгасан байдал	Тайлбар
<b>Радио телевизийн сүлжээний газрын санал</b>				
1		Шинээр барих олон давхар орон сууцны барилга ба амины орон сууцны МХСС-нд шугамын радиогийн монтажийг бүрэн оруулах	Тусгах боломжгүй.	Тус стандартад техникийн өрөөнөөс босоо болон хөндлөн сувагчлал шийдэгдсэн бөгөөд хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрсдөө шийдвэрлэх боломжтой
2		Шинээр барих олон давхар орон сууцны барилга ба амины орон сууцны МХСС-нд байрны дээвэр дээр шугамын радиогийн зогсуур суурилуулах талаар тусгах	Тусгах боломжгүй.	Мэдээлэл харилцаа холбооны техникийн өрөөний стандартад саналаа өгөх
3		Шинээр барих олон давхар орон сууцны барилга ба амины орон сууцны МХСС-нд байрны дээвэр дээр хүлээн авах антенн байрлуулах бетон суурь суурилуулах талаар суутгах	Тусгах боломжгүй.	Цамхгийн стандартад саналаа өгөх
<b>Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн санал</b>				
4	4.14 дотор холбооны сүлжээ (домофон)	Нэр томъёоны хэсэгт “дотор холбооны сүлжээ буюу Домофон” гэж шинээр оруулж ирсэн ч төлөвлөлтийн хэсэгт дурдагдаагүй байна.	Тусгав.	4.14 заалтыг хасав
5	4.23 сүлжээний хуваарилах төхөөрөмж (splitter) МХСС-ний төрөл бүрийн кабель шугамыг салаалах тэжээлийн хангамж	“МХСС-ний шилэн кабелийн шөрмөсийг салаалах тэжээлийн хангамж шаардахгүй хэрэгсэл” гэх	Тусгав.	Стандартын 4.23-д тусгав.

	шаардахгүй техник хэрэгсэл			
6	<b>идэвхитэй салаалагч (switch)</b> сүлжээний орчин үүсгэх зориулалтын төхөөрөмж	<b>идэвхитэй салаалагч (switch)</b> гэсэн нь MNS 5535:2005 стандартын нэр томъёоны тодорхойлолтын 3.2-т заагдснаас зөрүүтэй байна.	Тусгах боломжгүй.	Орчин үеийн үг хэллэгт тохируулан хэрэглэсэн болно.
7		<b>7 Орон сууцны барилгын МХСС төлөвлөх ерөнхий шаардлага</b> хэсэгт МХСС-ний төлөвлөлтийш төлөвлөлт хийгдэж байгаа нутаг дэвсгэрт МХХСС-ний ямар технологийн үйлчилгээ үзүллэх боломжтой байгааг харгалзан төлөвлөлтийг хийх шаардлагатай талаар оруулах	Тусгах боломжгүй.	Стандарт нь байж болох хамгийн бага хэмжээг тодорхойлдог бөгөөд илүү шаардлагуудыг захилагчийн хүсэлтээр хийнэ.
8		6.1.1-д “9 буюу түүнээс дээш давхар орон сууцанд 250 м тутамд техникийн өрөөг төлөвлөж өгөх” гэсэн нь ойлгомжгүй байна. Олон давхар барилга гэдэг нь 16 давхар буюу 51 м хүртэл өндөртэй барилгыг хамааруулна гэж барилгын норм дүрэмд байдагтай тодруулж шалгах	Зарим өөрчлөлтийг тусгав.	Шивэлтийн алдаанаас болсон 250м гэдгийг 25 болгож засварлав. 9 давхар гэдгийг Барилгийн нормд заасны дагуу “олон давхар” гэж өөрчлөв.
9		6.4.6-д давхар хоорондын кабелийн зам ... (үг оруулах) зорилгоор тааз, шаланд тэгш өнцөгт хэлбэртэй нүх гэснийг	Тусгав.	кабелийн замыг “хийх” зорилгоор гэж нэмэв.
10		9.3.4.8-д МХТ-ийн хандалтын сүлжээ (access network)-нд G652D зөвлөмжийн 30 мм-ийн диаметртэй кабель ашигласнаас G657 В3 зөвлөмжийн 10 мм хүртэл диаметртэй шилэн кабель ашиглахаар төлөвлөх нь илүү зохимжтой гэж үзэж байна.	Тусгав.	G657 В3 зөвлөмжийн 10 мм кабелийг нэмж оруулав.
11	<b>4.11</b> 19 инчийн зогсвор (Rack) МХСС-ны тоног төхөөрөмжүүдийг дотор нь суурилуулах зогсвор, өндөр нь 13 unit-ээс 45 unit хүртэл байна.	4.11-д 19 инчийн зогсворын өндрийн хэмжээг 13U-ээс бага байж болохоор оруулах	Тусгах боломжгүй.	Орчин үеийн мэдээлэл холбооны төрөл бүрийн үйлчилгээ нэвтэрч, смарт бюлдингийн чиг хандлага нэвтэрч, олон төхөөрөмж суурилагдах учраас хамгийн багадаа 13 unit гэж оруулсан.
	<b>6.3.3</b> Кабелийн сувагчлалд 110 мм-	6.3.3-т барилгад оруулах сувагчлалын хоолонй тоог 2-	Тусгах боломжгүй.	MNS 6668:2017 стандартын 4.4 заалтдад 2

12	ийн гадна диаметртэй хуванцар хоолой ашиглахаар төлөвлөнө. 2 хоолойтой сувагчлал оруулах оролтын хэмжээ 300мм х150 мм-ээс багагүй байна.	оор хязгаарласныг эргэж харах. Орон сууцны хороололд техникийн өрөөнд орох ба гарах кабелийн тоо олон болох тохиолдол гардаг тул энэ талаар тайлыар хийж өгөх.		хоолой гэж заагдсан байгаа.
13		9.1.3-т 4-р хүснэгтэнд Барилгын айлын тооноос хамааруулан босоо сувагчлалын орон зайг төлөвлөсөн байна. Энэ төлөвлөлтийг ББ-ийн төлөвлөлтөөр хийх тул 6.4.6-д оруулах нь зүйтэй гэж үзлээ.	Тусгах боломжгүй.	6.4-р бүлэг нь орон сууцны сувагчлалын орон зайн тухай бөгөөд 9.1.3 нь кабель шугамын тухай болно.
14		Одоо мөрдөгдөж байгаа стандартын 9.3.4.12-р заалтыг хасах шалтгаан нь юу байсан бэ?	Тусгав.	Бичилтийн алдаанаас хаягдсан байсныг нэмж оруулав.